

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2023 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРАЛД БҮРТГЭЛ ХЯНАЛТАД АВСАН ЗАХИРАМЖИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАН

2023 оны 05 дугаар сарын 31

Мандалговь хот

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

Аймгийн Засаг даргын 2023 оны 1 дүгээр улиралд батлан гаргасан захирамжийн хэрэгжилтийн үр дүнг үнэлэх, зөвлөмж гаргах, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах, захирамжийн хэрэгжилтийн үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулахад хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго оршино.

ХОЁР.ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ

Аймгийн Засаг даргын 2023 оны 1 дүгээр батлан гаргасан хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.3-т заасан аргачлалаар хийлээ.

Аймгийн Засаг даргаас 2023 оны 1 дүгээр улиралд 20 захирамжийн 23 заалтыг хяналтад авч, Төрийн захиргааны, удирдлагын хэлтэс холбогдох сум, хэлтэс, агентлагуудаас биелэлтийг гаргуулан авч нэгтгэн тайланг 2023 оны 5 сарын 30-ний өдөр эцсийн байдлаар ирүүлсэн.

ГУРАВ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Аймгийн Засаг даргын 2023 оны 1 дүгээр улиралд хяналтад авсан 20 захирамжийн 23 заалт 87.8 хувийн хэрэгжилттэй байна. Үүнээс 100 хувь -15, 70 хувь -7, 30 хувь -1 заалт байна.

Дүнгээс харахад: Бүрэн хэрэгжсэн буюу 100 хувьтай 15 заалт нь нийт заалтын 65.2 хувийг, хэрэгжих шатандаа буюу 70 хувьтай хэрэгжиж байгаа 7 заалт нь 30.4 хувийг, хэрэгжилт хангалтгүй буюу 30 хувьтай хэрэгжиж байгаа 1 заалт нь 4.3 хувийг, тус тус эзэлсэн байна.

Тайлангийн хугацаанд дараах арга хэмжээнүүд үр дүнтэй хэрэгжсэн байна.

1. Аймгаас 2023 оны Боловсролын чанар хүртээмжийг дэмжих жил болгож зарласантай холбогдуулан ажлын хэсэг томилж тухайн жилд хийх ажлын төлөвлөгөөг 38 заалттайгаар боловсруулан батлуулж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна. Дэвшүүлсэн зорилтын хүрээнд орон нутгийн төсвөөс 487,6 сая, улсын төсвөөс 284,7 сая төгрөгийг зарцуулахаар төсөвлөсөн байна.

2. Өвөлжилт хаваржилт хүндэрсэнтэй холбогдуулан аймгийн хэмжээнд 18144 боодол өвс, 16808 ш тэжээл хуваарилан олгохоос 18347 боодол өвс, 183810 тн тэжээл олгосон. Монгол Улсын Засгийн газрын улсын нөөцөөс өвс, тэжээлийг 50 хувь хямдруулан олгох 2022 оны 461 дүгээр тогтоолын дагуу аймгийн Засаг дарга, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэстэй хамтран сумдад нөөцийн барааг хуваарилан улсын нөөцөөс хямдруулсан 6500 төгрөгийн үнэтэй

1000 боодол өвсийг малчдад бүрэн олгож 6.500.000 төгрөгийг төвлөрүүлэхээс Онцгой байдлын ерөнхий газрын 100900031005 тоот дансанд 6.500.000 төгрөгийг 100 хувь төвлөрүүлсэн байна.

3. 2023 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн А/39 тоот захирамжийн дагуу Тэвшийн говь" ХХК-ний 1, 2 дугаар усан халаалтын зуухны үйл ажиллагааг хүлээн авч засвар үйлчилгээг хийж гүйцэтгэн 449 айл өрх, 49 ААН төсөвт байгууллагыг дулаанаар хангах ажлыг гэрээний үүргийн дагуу гүйцэтгэж 5 дугаар сарын 1-ний өдрийн байдлаар халаалт зогссон. Ингэснээр иргэдээс Тэвшийн говь ХХК-ны халаалттай холбоотой гардаг гомдол шийдвэрлэгдсэн байна.

4. Жилийн эцсийн үйл ажиллагааны үр дүнгээр дутагдалтай үнэлэгдсэн Дэрэн, Өлзийт, Цагаандэлгэр, Хулд сумдын Засаг даргын Тамгын газар, төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд зөвлөн туслах ажлыг Тамгын газрын даргын баталсан удирдамжийн дагуу төлөвлөлт ба тайлагналтад анхаарах асуудал, цахим ур чадварыг нэмэгдүүлэхэд анхаарах асуудал, архив, албан хэрэг хөтлөлтийн стандарт дараах сургалтуудыг зохион байгуулсан. Сургалтад нийт 65 албан хаагч хамрагдсан байна.

5. Жилийн үйл ажиллагааны үр дүнгээр дутагдалтай үнэлэгдсэн Стандарт хэмжилзүйн хэлтэс, Мал эмнэлгийн газар, Нийгмийн даатгалын хэлтэс, Соёл урлагийн газар, Эрүүл мэндийн даатгалын хэлтэс, Шүүхийн шинжилгээний алба зэрэг агентлагуудад Засаг даргын тамгын газрын даргын удирдамжийн дагуу бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилт болон төрийн байгууллагуудын мэдээллийн ил тод нээлттэй байдлын хэрэгжилттэй танилцан, ажил эрчимжүүлэх чиглэлээр мэдээлэл арга зүйгээр ханган, байгууллагын үйл ажиллагаанд зөвлөн туслах үйлчилгээг үзүүлж ажилласан зэрэг үр дүнтэй ажлуудыг зохион байгуулсан байна.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Аймгийн Засаг даргаас батлан гаргасан захирамжийг 2023 оны 1 дүгээр улиралд 87.8 хувьтай хэрэгжиж байна. Энэ улиралд хэрэгжилт тооцсон захирамжуудаас дараах заалтууд хэрэгжилт удаашралтай байгаа болон эрчимжүүлэх шаардлагатай байна. Үүнд:


2023 оны Эрх шилжүүлэх тухай А/43 тоот захирамжаар Эрдэнэдалай сумын хүүхдийн ордны засвар, Дэрэн сумын цэцэрлэгийн гадна фасадын засварын эрхийг шилжүүлж Эрдэнэдалай сумын хүүхдийн ордны засварын тендер зарласан боловч оролцох компани ирэхгүй байгаа учраас захиалагчаас тендерийн баримт бичигт өөрчлөлт оруулах хүсэлт гаргасан байна. Дэрэн сумын цэцэрлэгийн гадна фасадын засварын тендерийг зарлаж хамгийн сайн тендерийг шалгаруулсан боловч тендерт шалгаруулаагүй компаниас гомдол гарснаас энэ заалтын хэрэгжилт удаашралтай байгаад анхаарал хандуулж ажиллах


Боловсролын чанар хүртээмжийг дэмжих жилийн ажлын хүрээнд сум, агентлагуудын төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хагас бүтэн жилээр гаргуулан авч хэрэгжилтийн байдлыг нэгтгэж тайлагнаж байхаас гадна зарцуулсан хөрөнгийн хэмжээг тооцон гаргах

Эрх шилжүүлэх тухай А/43 тоот захирамжийн 2 дах заалтын хэрэгжилтийг эрчимжүүлэх

“Амьдралын зөв дадал хэвшлийг төлөвшүүлэх” арга хэмжээнд нийт 15 сум, 23 агентлагийн 796 иргэн хамрагдаж байгаа боловч хамрагдалт төдийлөн хангалттай биш байгаа учраас сум, байгууллагын хамрагдалтын мэдээг улирал бүр гаргаж, сум байгууллагуудын удирдлагуудыг мэдээллээр хангаж байхаас гадна хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах

Өгсөн зөвлөмжийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг 2 улирлын захирамжийн хэрэгжилттэй хамт ирүүлэх

Тайлан хянасан:
Хяналт-шинжилгээ, үнэлгээний
хэлтсийн дарга  Д.Даариймаа

Тайлан бичсэн:
Хяналт- шинжилгээ, үнэлгээний хэлтсийн
ахлах мэргэжилтэн  Э.Одончимэг

